



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/129

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан уриатай уялдуулан “Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эрх” уриан дор аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Сарын аян зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, сарын аянд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сарын аяныг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

4.Сарын аян зохион байгуулах 5,360,240 (таван сая гурван зуун жаран мянга хоёр зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0327

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 21-ны өдрийн 1122 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНЫ ТУХАЙ**



НЭГ. ЗОРИЛГО

Төрөөс баримталж буй бодлого, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль түүнийг дагаж гарсан дүрэм журам стандартийг хэрэгжүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар олон нийтэд сурталчилах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, ажилтан үйлдэрлэлийн осолд өртөхгүй, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулахад сарын аяны зорилго оршино.

ХОЁР. ХУГАЦАА

2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01

ГУРАВ. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Нийгмийн даатгалын хэлтэс

Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо

Аймгийн Ажил олгогч эздийн холбоо

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах

Аж ахуйн нэгж байгууллага бүр ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн эрсдэлийн анхан шатны үнэлгээг хийж аймгийн ХАБЭА-н зөвлөлд ирүүлэх

Эрсдэл өндөртэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах

Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг эрчимжүүлэх

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид мөн жижиг дунд үйлдвэрлэгчдийн дунд ХАБЭА-н талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах

Хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н талаар иргэдээс санал, асуулга авч үүний хүрээнд тодорхой салбаруудад үзлэг шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

Аж ахуйн нэгж байгууллагууд "Аюулгүй ногоон ажлын байр" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, сайн туршлагын нийгэмд түгээх

"НЭН ТЭРГҮҮНД ХАБ" нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

ТАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Аймгийн нийт аж ахуйн нэгж, байгууллага, ажилтан, албан хаагчид, иргэд,

ЗУРГАА. ДҮГНЭХ

Удирдамжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг аж ахуйн нэгж байгууллага 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөрт багтаан Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд ирүүлэх

Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ны өдрийн 01/179 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН САРЫН АЯНЫ ТӨСӨВ

№	Хийгдэх ажил	Шаардагдах материал	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн зардал	Нийт зардал
1	“Эрүүл аюулгүй ажил- Бидний суурь эрх” сарын аяны шторк хийх	2 минут	1	минут	300,000	600,000
2	Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийг сурталчлах арга хэмжээ (Уянга, Бат-Өлзий, Нарийнтээл, Сант, Баян-өндөр)	Постер	5	ш	95,000	475,000
		Шатахууны зардал (сумдад ажиллахад шаардагдана) 4-5 сум	468	л	2470	1,150,960
		Ажил олгогч, ажилтанд зориулсан гарын авлага	300	ш	1500	450,000
		Томилолт	3 хүн* 5 хоног	хоног	64,000	960,000
		Шатахуун	60	л	2470	148,200
3	Хархорин, Хужирт сумдад ХАБЭА-н сарын аяны нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, хуулийг сурталчилах	Томилолт	6 хүн* 2 хоног	хоног	64,000	768,000
4	ХАБЭА-н сарын аяны хүрээнд сайн зохион байгуулсан, үйл ажиллагаа нь сайн явагдаж байгаа хувийн хэвшлийн болон төрийн өмчит компанийг шалгаруулж урамшуулах	1-р байр	1	ш	300,000	300,000
		2-р байр	1	ш	200,000	200,000
		3-р байр	1	ш	150,000	150,000
5	256-р анги, Баянтээг ХК-нд ХАБЭА-н үзлэг хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах	Шатахууны зардал 200 км*2=400км	64	л	2470	158,080
ДҮН						5,360,240